



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 4/17

Бор-өндөр сум

Нэмэлт ор дэлгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Бор-Өндөр суманд томуу, томуу төст өвчний дэгдэлт эхэлж, бага насны хүүхдүүд ихээр өвдөж ачаалал нэмэгдсэн, цаашид нэмэгдэх хандлагтай байгаа тул 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдрөөс эхлэн хүүхдийн тасагт нэмэлтээр 20 ор дэлгэн ажиллуулсугай.
2. Хүүхдийн тасагт нэмэлт ор дэлгэх, орны бэлэн байдлыг хангах, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, эм бэлдмэлийн нөөцийг бэлэн байлгах, бэлтгэл ажлыг шуурхай удирдлагаар хангаж, зохион байгуулж ажиллахыг Удирдлагын багт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дарга (Б.Энхмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.БАТБААТАР